# САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ, АХЛАХ ШИНЖЭЭЧ ЛХААСҮРЭНГИЙН ГЭРЭЛМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх дуусах хугацаа | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эхний хагас жил | сүүлийн хагас жил | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | |
| **Зорилт 1. Салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1.** Хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хяналт шалгалтын дүнд үндэслэн судлан нэгтгэж, боловсронгуй болгох саналыг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ. | Хүргүүлсэн тайлан, санал | 2023 оны тайлан, санал | 2024 оны хяналт шалгалтын дүнд үндэслэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг гарган, холбогдох саналыг боловсруулж ХҮҮХ-нд хүргүүлсэн байна. | - | 02-03 сар | Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр 2024 онд хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг 11 байгууллагад 89 заалт, холбогдоох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр 9 хуульд 19 заалт, 24 дүрэм журам, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж ХҮҮХ-ны даргад 2025.02.21-ний өдрийн 1а/983 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Хяналт шалгалтын обьектын эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, саналыг ХҮҮХ-нд хүргүүлнэ. | Шинэчлэн боловсруулсан шалгуур үзүүлэлтийн тоо | Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолоор батлуулсан 13 шалгуур үзүүлэлт | Шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулж санал авсан байна | Шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж ХҮҮХ-нд хүргүүлсэн байна. | 02-06 сар | Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах Засгийн газрын 2023 оны 195 дугаар тогтоолоор батлуулсан 3 хяналтын чиглэлийн 16 төрлийн шалгуур үзүүлэлтэд нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, 2 төрлийн шалгуур үзүүлэлт шинээр боловсруулж, улсын байцаагчдаас саналыг авч тусган, танилцуулга, холбогдох мэдээллийг боловсруулж, ХҮҮХ-нд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлэхээр удирдла гуудаар хянуулж Сайд дээр хүлээгдэж байна. | |
| 3. | **Арга хэмжээ 1.3.**Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан журамд нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. | ЭМС-ын тушаал | ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаал | Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын үйл ажиллагааг зохицуулсан журамд нэмэлт өөрчлөлт оруулж боловс руулна. | Журмыг шинэчлэн боловс руулж батлуул сан байна. | 04-10 сар | "Эрүүл мэндийн салбарын хяналтын үйл ажиллагааг зохицуулах журам"-д шинээр 1 хавсралт, 2 зүйл, 12 заалт, шинэчилж найруулсан 32 заалтыг боловсруулж, "Объек тыг хяналт шалгалтад хам руулах давтамжийн хугацаа", "Улсын байцаагчийн жилийн ажлын хөдөлмөрийн жишиг норматив", "Нэг объект шалга хад зарцуулах хугацааны норматив", "Нэг объектын гүйцэтгэлийг шалгахад зарцуу лах хугацааны норматив"-т эм эмнэлгийн хэрэгслийн хяналтын чиглэлийг нэмж, боловсролын сургалтын байгууллагад хийх хяналт шалгалтын давтамжийн хугацаанд өөрчлөлт оруулан, "Улсын байцаагчийг чадавхи жуулах сургалт зохион байгуулах заавар"-т сургалтын төрлийг нэмж, хэрэгцээний судалгаанд үндэслэн давтан сургалтыг хийх, "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед улсын байцаагчийн ажиллах заавар"-ыг шинээр боловсруулж ЭМС-ын 2025 оны 05 сарын 01-ний өдрийн А/168 дугаар тушаалаар батлуулж, АНЭМГ, ЭЭХХЗГ-т албан бичгээр хүргүүлсэн.<br>2025.06.09-ний өдөр СХГ, аймаг, нийслэлийн байцаагч нарт цахимаар батлуулсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | **Арга хэмжээ 1.4.**Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлж батлуулна. | Батлагд сан хяналт шалгалтын төлөв лөгөө | 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөө | - | 2026 оны хяналт шалгалтын төлөвлө гөөг боловс руулж Батлуул сан байна. | 10-12 сар | 2025 оны 4 дүгээр улирлын 10-12 сард хийгдэнэ.<br><br>Хугацаа болоогүй | - |
| 5. | **Арга хэмжээ 1.5.**Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт тайланг Хяналт, үнэлгээний үндэсний хороонд хүргүүлнэ. | Хяналт шалгалтын төлөвлө гөөний биелэлт тайлан | 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө ний биелэлт тайланг ХҮҮХ-нд 2024.12.05-ны өдөр хүргүүлсэн. | - | 2025 оны хяналт шалгалтын нэгтгэл тайланг ХҮҮХ-нд хүргүүлсэн байна. | 11-12 сар | 2025 оны 4 дүгээр улирлын 11-12 сард хийгдэнэ.<br><br>Хугацаа болоогүй | - |
| 6. | **Арга хэмжээ 1.6.** Улсын хэмжээнд 2026 онд хяналт шалгалтад хамрагдах обьектын жагсаалтыг гаргаж батлуулна. | ЭМС-ын тушаал | 2025 оны хяналт шалгалтад хамрагдах обьектын жагсаалт ЭМС-ын 2024 оны А/496 дугаар тушаал | - | 2026 онд хяналт шалгалтад хамрагдах обьек тын жагсаал тыг ЭМС-ын тушаалаар батлуул сан байна. | 11-12 сар | 2025 оны 4 дүгээр улирлын 11-12 сард хийгдэнэ.<br>Хугацаа болоогүй | - |
| **Зорилт 2. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан хяналт шалгалтын төлөвлөгөө болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | **Арга хэмжээ 2.1**. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөв лөгөөт, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулах, хяналт шалгалтын баримт бичгийг хянана. | Хяналт шалгалтын нэгдсэн танилцуул га<br>Хянасан хяналт шалгалтын баримт бичиг | 2024 оны хяналт шалгалтын танилцуулга | Хяналт шалгалтын удирдамж, хяналтын хуудсуудыг хянаж батлуулсан байна. | Хяналт шалгалтын төлөв лөгөөний хэрэг жилтийг хангуулж, хяналт шал галтын нэгдсэн танил цуулгуудыг хянасан байна. | 01-12 сар | **1**.Хяналт шалгалтын үйл ажил лагааг улсын хэмжээнд уял дуулан зохицуулж, ЭМС-ын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөг боловсруулж, ХҮҮХ-ны 2024.11.29-ний өд рийн 02 тогтоолоор батлуулан, АНЭМГ-ын улсын байцаагчдад хүргүүлсэн.<br>**2**.ЭМЯ-ны Гүйцэтгэлийн төлөв лөгөөнд СХГ-ын хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн боловсруулж тусгуулан батлуулсан.<br>**3**.Салбарын хяналтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгт гэн боловсруулж 2025.01.06-ны өдөр батлуулан, АНЭМГ-уудад хүргүүлсэн. Сар, 7 хоногийн төлөвлөгөө боловсруулж батлуулан, биелэлтийг гарган удирдлага, холбогдох газарт хүргүүлсэн.<br>**4**.Хяналт шалгалтын удирдам жийг ХШХНЖ-д заасны дагуу боловсруулах чиглэлээр зөв лөмж боловсруулж улсын ахлах байцаагчдад хүргэсэн ба хяналтын 5 чиглэлийн төлөв лөгөөт хяналт шалгалтын 5, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 16 төрлийн удирдамжийг хянаж, жигдлэн батлуулсан.<br>**5**.Хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулсан болон шинээр боловсруулсан хяналтын хуудсуудыг 2-3 удаа хянаж, 70 хяналтын хуудсыг 2025.01.31-ний өдрийн А/26 дугаар тушаалаар батлагдсан.<br>**6**.Өмнөговь, Дорнод аймагт хийх удирдамж боловсруулж батлуу лан, хяналт шалгалтыг ахалж, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийт сургалтын боловсролын байгууллагын 11 объектод хяналт шалгалт хийж, шалгалтын дүн нэгтгэж нэгдсэн танилцуулга, шалгалтад хамрагдсан 11 байгууллагад нийт 208 заалт бүхий 11 албан шаардлагыг боловсруулсан.<br>Хяналт шалгалтын дүнг УЗХ-ын 2025.04.24-ний өдрийн хурлаар оруулан хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар 5 заалт бүхий шийдвэр гаргуулсан. Шалгалтын дүн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр аймгийн Засаг дарга, сумын Засаг дарга, аймгийн ЭМГ, БГ, Боловсролын яаманд тус тус албан бичгээр хүргүүлсэн. | |
| **Зорилт 3. Орон нутаг дахь улсын /ахлах/ байцаагчдыг бодлого, удирдлага, мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангана.** | | | | | | | | |
| 8. | **Арга хэмжээ 3.1.** ЭМС-ын 2024 оны А/309 дүгээр тушаалын 6 дугаар хавсралтын 2.1, 2.1.1 дэх заалт<br>Шинэ байцаагчдад баримжаа олгох сургалт, орон нутаг дахь улсын байцаагчдыг чадавхи жуулах давтан сургалтыг нэгдсэн зохицуулалтаар хан гаж зохион байгуулна. | Сургалтын хэрэгцээний үнэлгээ Зохион байгуулсан<br>сургалтын тоо | Сургалтын тайлан | Сургалтын хэрэгцээний үнэлгээ хийсэн байна.<br>Шинэ байцаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулж батлуулсан байна | Сургалт зохион байгуулсан нэгдсэн тайлан гаргасан байна. | 02-11 сар | **1**.Улсын байцаагчдын судалгааг шинэчилж нийт 102 улсын байцаагчаас авч нэгтгэсэн.<br>**2**.Улсын байцаагчдын сургал тын хэрэгцээний судалгаа хийх аргачлал" боловсруулж бат луулсан.<br>**3**.Салбарын хяналтын газар болон НЭМГ, 21 аймгийн ЭМГ-ын нийт улсын байцаагчдаас аргачлалын дагуу судалгаа авч нэгтгэн, 5 хяналтын чиглэлээр сургалтын сэдэв тус бүрээр, зохион байгуулах хугацаа, сургалтын хэлбэр, зохион байгуулах газар, хичээл заах багшийн төрлөөр гаргаж давхардсан тоогоор 160 сэдвээр сургалтын хэрэгцээ шаардлага байгааг гарган | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Салбарын хняалтын газрын улсын ахлах байцаагчдад хүргүүлсэн.<br><br>**4**.Журмад заасны дагуу Шинэ байцаагчид баримжаа олгох сургалтын хөтөлбөр боловс руулж батлуулан, хичээлүүдийг ррт хэлбэрээр бэлтгэсэн. Тайлант хугацаа буюу 2025.01.02-2025.06.09-ний хооронд 2 удаа 11 газрын 20 улсын байцаагчид сургалтыг цахимаар зохион байгуулсан. | |
| 9. | **Арга хэмжээ 3.2.** Улсын байцаагчдад зориулсан хяналт шалгалтын эрх зүйн баримт бичгийг эмхэтгэж гарын авлага гаргана. | Гарын авлага | - | Гарын авлага гаргаж улсын байцаагчдад хүргүүлсэн байна. | - | 02-06 сар | Улсын байцаагчдад зориулан Засгийн газрын 6 тогтоолоор батлагдсан 5 журам, Сайдын 6 тушаалаар батлагдсан 10 журам, нийт 15 эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн, 60ш хэвлүүлж, шинээр эрх авсан улсын байцаагчдад тарааж байна. | 100 |
| **Нэмэлтээр хийгдсэн ажил** | | | | | | | | |
| 1. | Улсын байцаагчийн эрх олгох цуцлахтай холбоотой асуудлыг зохицуулах | Сайдын тушаал Албан бичиг | - | Хүсэлтийн дагуу улсын байцаагчийн эрх олгох, цуцлах асуудлыг шийдвэрлэн хариу хүргүүлсэн байна. | Хүсэлтийн дагуу улсын байцааг чийн эрх олгох, цуцлах асуудлыг шийдвэр лэн хариу хүргүүлсэн байна. | 01-06 сар | **1**.Улсын хэмжээнд байцаагчдын тамга, тэмдгийн судалгааг албан бичиг хүргүүлэн авсан.<br><br>**2**.Тайлант хугацаанд 13 газраас ирүүлсэн албан хүсэлтийн дагуу улсын байцаагчийн эрх олгох, цуцлахтай холбоотой бичиг баримтыг хянаж, ЭМС-ын 5 тушаалаар 10 газрын 14, 7 тушаалаар давхардсан тоогоор 21 газрын 29 улсын байцаагчид эрх олгох нийт 12 тушаалыг гаргуулан, 10 газрын 14 улсын байцаагчийн эрх цуцлах, нийт 12 тушаалыг гаргуулан, тус бүрийг албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | АТТ боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах | | | | | | **1**.Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагчдын чиг үүргийг боловсруулж, ТЗУГ-т хүргүүлсэн.<br><br>**2**.Салбарын хяналтын газрын албан хаагчдын АТТ-ыг боловс руулж, холбогдох журмын дагуу харьцуулалт, нэмэлт мэдээллүү дийг гаргаж ажлын хэсэгт хүргүүлэн, ТАЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхэд оролцож, батлуулсан. | |
| 3. | НЭМАХҮТ болон НЭМТ байгуулах болон төвийн дүрмийг боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Боловсруул сан баримт бичиг | - | Ажлын хэсгийн төлөвлөгөө ний дагуу ажилласан байна. | Ажлын хэсгийн төлөвлө гөө ний дагуу ажилласан байна. | 02-12 сар | **1**.ЭМС-ын 2025.02.13-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар байгуулагдсан НЭМАХҮТөв болон дүрэм боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн АТТ-уудад дүн шинжилгээ хийж, ажлын хэсэгт танилцуулсан.<br><br>**2**.Аймаг, нийслэл, дүүргийн НЭМТ, өрх, сум тосгоны ЭМТ байгуулах болон төвийн дүрмийг боловсруулах ажлын хэсэгт ажил лаж, АТТ-уудад дүн шинжилгээ хийж ажлын хэсэгт танилцуулсан. | 100 |
| 4. | Монгол Улсад тохиолдож болзошгүй нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга эхмжээний ядавхийн үнэлгээ хийх, холбогдох баримт бичгийг боловсруулах салбар хоорондын ажлын хэсэгт ажиллах | Боловсруул сан баримт бичиг | - | Ажлын хэсгийн төлөвлөгөө ний дагуу ажилласан байна. | Ажлын хэсгийн төлөвлө гөө ний дагуу ажилласан байна. | 02-12 сар | УОК-ын даргын 2025.02.14-ний өдрийн 02 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, Эрсдэлийн зураглал боловсруулах багийн ахлагчаар ажиллаж, байгалийн аюулт үзэгдэл, цацраг идэвхит бодис алдагдах, хүний халдварт өвчний тандалтын тэргүүлэх чиглэлийн өвчин, зоонозын халдварт өвчнүүдээр эрсдэлийн зураглалыг гаргаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Эрүүл ахуйн тухай хуулийн үр дагаврын үнэлгээ хийх ажлын хэсэгт ажиллах | Үнэлгээний тайлан | - | Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ажилласан байна. | Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ажилласан байна. | 03-12 сар | Эрүүл ахуйн тухай хуулийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлалыг боловсруулж НЭМБГ-т хүргүүлсэн, хуулийн хэрэгжилт гаргах асуумжийг боловсруулж, 4 жилийн хэрэгжилт гаргахаар ажиллаж байна. | 100 |
| 6. | **Бусад** | | | | | | -Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсрал таар баталсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, 2025.04.25-ны өдрийн 1а/2053 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br><br>-СУЕБ-ийн Албан даалгаврыг хамтран боловсруулж, АНЭМГ-уудад хүргүүлсэн.<br><br>-Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар зарим арга хэмжээний тухай УИХ -ын 2022 оны 36 дугаар тогтоолтой холбогдуулан Хүнсний аюулгүй байдлын хангах тухай хуулийн салбарын хяналтын чиг үүрэгтэй холбоотой заалтуудын хэрэгжилтийг гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br><br>-УЗХ-ын 2024 оны төлөвлө гөөний биелэлт, 2025 оны төлөвлөгөөнд 5 чиглэлээр хийсэн хяналт шалгалтын дүнг оруулж хэлэлцүүлэхээр боловс руулж, ТЗУГ-т хүргүүлсэн.<br><br>-ЭМЯ-ны Хөдөлмөрийн дотоод журамд санал боловсруулж ТЗУГ- | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ын XX-т хүргүүлсэн.<br><br>-Аймгийн ЭМГ-ын бүтцийн төсөлд тус газрын ХШХ, улсын байцаагчдын орон тооны саналыг боловсруулж, холбог дох материалыг бүрдүүлэн удирдлагад танилцуулав.<br><br>-ЭТБГ-аас ирүүлсэн ХБИ-ий үйлчлүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2023-2024 онд хийсэн хяналт шалгалтын дүнг хяналтын чиглэл бүрээр нэгтгэн боловсруулж, хүргүүлсэн.<br><br>-"Эрүүл мэндийн салбарын чиглэлээр 2024 онд гүйцэтгэсэн хяналт шалгалт, үр дүн, 2025 оны төлөвлөлт, анхаарах асуудал" сургалтыг улсын хэмжээнд АНЭМГ-ын байцаагч нарт зохион байгуулав. Хяналт шалгалтын нэгдсэн мэдээлэл, анхаарах асуудлын талаар ррт бэлтгэж хүргүүлэв.<br><br>-"Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний удирдлага зохион байгуулалт" гарын авлага боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, холбогдох бүлгүүдэд мэдээллийг оруулж, гарын авлагыг хянаж хүргүүлсэн.<br><br>-ЭМЯ-ны холбогдох газруудаас ирүүлсэн 44 дотоод меморандумын хариуг хүргүүлсэн. | |

**Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх дуусах хугацаа | Хүрсэн түвшин(биелэлт) | Бие-лэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эхний хагас жил | сүүлийн хагас жил | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | | |
| 1. | **Арга хэмжээ 1.** Хариуцсан ажлын чиглэлээр холбогдох гэрчилгээтэй сургалтад хамрагдана. | Сургалтын гэрчилгээ | 2 | 2 | - | 02-05 сар | **1**.Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдах сонгон шалгуурлалтад эссэ бичиж шалгаран "Төрийн бодлого, бодлогын шинжилгээ, бодлогыг бүтэн циклээр нь харах нь" сургалтад хамрагдаж сертификат авсан./2025.02.24-25<br>**2.-3**."Төлөвлөлт, мониторинг үнэлгээний арга" сэдэвт 2 шатны зайн сургалтад хамрагдаж, сертификат авсан./2025.03.10-14, 2025.04.14-19<br>**4**.Төлөвлөлт, мониторинг, үнэлгээний арга" туршлага судлах сургалтад БНСУ-д очиж суралцаж, сертификат авсан./2025.03.23-30<br>**5**.Design, monitoring, and evaluation" богино хугацааны сургалтад хамрагдаж сертификат авсан./2025.05.14-16 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой болон хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх сургалтад хамрагдана. | Хамрагд сан сургалтын тоо | 3 | 1 | 1 | 05-11 сар | Улсын ерөнхий прокурорын газраас "Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор зохион байгуулж байгаа сургалтад Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын нийт 52 улсын байцаагчийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамруулан 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр хамтран зохион байгуулж, хамрагдсан. | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ................................ / Л.ГЭРЭЛМАА / 2025.06.09

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*